


**БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН  
МЕНЕЖМЕНТИЙН АШИГЛАЛТ,  
ХАМГААЛАЛТЫН БОДЛОГО**



Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын  
газрын дарга Г.Нямдаваа

ОУ-н Байгаль орчны  
Гэрээ, Конвенциуд  
12 конвенц, 5 протокол

Тогтвортой Хөгжлийн Зорилгууд  
17 зорилго, 168 үзүүлэлт



МУ-ын Тогтвортой хөгжлийн  
үзэл баримтлал - 2030

МУ-ын байгаль орчны хуулиуд  
30 гаруй

Байгаль орчны Үндэсний  
хөтөлбөрүүд  
17 хөтөлбөр

МУ-ын ЗГ-ын Үйл ажиллагааны  
хөтөлбөр 2016-2020  
4 дүгээр бүлэг: Байгаль орчин,  
ногоон хөгжлийн бодлого


# Байгалийн нөөц баялаг:

- Ой
- Ус
- Ургамал
- Амьтан
- Газрын хэвлий



## Нөөц: Ойгоор бүрхэгдсэн талбай нийт нутаг дэвсгэрийн 7.8 % буюу 12,280,000 га (2016)

Зайнаас тандан судлалын мэдээгээр засаж сайжруулсан  
Монгол орны ойн сангийн зураг




### Хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Олон улсын жишигт нийцсэн ойн мэргэжлийн байгууллагын итгэмжлэлийн үндэсний стандартыг бий болгосон.
- Ойн хөнөөлт шавжийн судалгааны ажлыг 16 аймгийн 110 сум, Нийслэлийн ногоон бүс, Богдхан уулын ДЦГ, Тусгай хамгаалалтай газар нутагт 4,6 сая га талбайд хийсэн
- Хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 9 аймгийн 23 сумын ойн санд 220,8 мянган га талбайд биологийн болон байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар хийсэн.
- 784,064 ширхэг мод, бутыг 88,8 мянган иргэн, 5388 аж ахуйн нэгж, байгууллага тарьж 862,7 сая төгрөгийг зарцуулсан.



Ойн түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэл зэргээс сүүлийн **5 жилд** ойгоор бүрхэгдсэн талбай **864.5 мян.га-аар багасчээ.**

2017 онд нийт 14 аймгийн 58 суманд **192** удаагийн ой, хээрийн түймэр гарснаас ойн **56,000** га талбай, хээрийн **115,907** га талбай өртсөн байна.



## Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- ОХУ-тай хиллэх Улсын хилийн дагуу 10-40м өргөн, 601,1 км урт **түймрээс хамгаалах зурвас**, хилийн багана, мэдээллийн самбар, хориглох тэмдэгүүдийг байрлуулав.
- Түймрийн эрсдэлтэй бүс нутаг дах УТХГН-ийн 14 захиргаа, Сумын, сум дундын 23 ойн ангид ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зориулалтын **багаж, машин, тоног төхөөрөмжөөр** хангав.
- Цаг агаарын болон ой, хээрийн түймрийн **шуурхай мэдээллээр** ОБЕГ болон бусад байгууллага, хүн амд үйлчилгээ үзүүлж байна.




## Парисын гэрээ: Ойн салбарын хувь нэмэр

Ойгоор бүрхэгдсэн талбайг **2030** он гэхэд **9%-д** хүргэх, **түймэрт** өртсөн талбайг **30%-иар** бууруулж, улмаар нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлж, ялгарлыг бууруулах

2016 он: Ойн нүүрстөрөгчийн шингээлтийн хэмжээ: **147,8тн/га**

Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн тоо



## Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Ой хээрийн түймрийн 70 гаруй хувь нь иргэдийн болгоомжгүй үйлдлээс болж гарч байгаа тул **мэдээлэл түгээх, хяналт, хариуцлагыг** илүү үр дүнтэй аргаар хэрэгжүүлэх
- Ой бүхий аймаг, сумдад улирлын урамшуулалттай түймрийн эргүүлийг **иргэд, ойн нөхөрлөлүүдтэй** хамтран гаргах, сайн дурынханд зориулсан сургалт явуулж түймэр унтраах ажилд оролцох боломжоор хангах
- МУ-д **Ойн экологийн нөхөн сэргээлт** хийх үндэсний чадавхийг буй болгох, ялангуяа түймэрт шатсан ойн нөхөн сэргээлтэд онцгойлон анхаарах



7

Төрөл	Эзлэх хэмжээ /км <sup>3</sup> /	Эзлэх хувь
Нуур	500	88.52
Гол, мөрөн	34.6	6.12
Мөнх цас, мөсөн гол	19.4	3.43
Газрын доорхи ус	10.8	1.9

Жилд хуримтлагдан бий болдог нийт нөөц: **564.8 км<sup>3</sup>**, гэтэл нийт ус ашиглалтын 70-80%-ийг нийт нөөцийн **1.9%** болох газрын доорхи усаар хангаж байна.

Улсын хэмжээнд **21** сав газрын захиргаадад нийт **208** хүн ажиллаж байна. **Үр дүн:**

- усны сав газарт хамгаалалт эрс сайжирсан,
- хяналтгүй, үрэлгэн ус ашиглалтыг хязгаарласан,
- төсөвт орох ус ашигласны төлбөрийн орлого нэмэгдсэн.

## Хэрэгжүүлж буй арга хэмжээ:

- Усны эх ундарга, эх үүсвэрийг хамгаалах,
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлж усны бохирдол, хомсдлыг бууруулах,
- Хурын ус хуримтлуулж усан сан, хөв цөөрөм байгуулах, газрын доорх усны ордыг тэжээх,
- Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны сав газрын захиргаадыг бүс нутагтаа мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг төвүүд болгон бэхжүүлэх,
- Улсын хэмжээнд газрын доорх усны хяналт-шинжилгээний 193 цэгийг усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээнд холбон, [groundwater.mn](http://groundwater.mn) сайтад оруулж, мэдээллийг тогтмол хянах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

2017 оны байдлаар улсын хэмжээнд **47** тэрбум төвлөрсөн.

8

## Тулгамдаж буй асуудлуудаас:

- Гадаргын усыг хуримтлуулан хөв, цөөрөм байгуулж усны нөөцийг нэмэгдүүлэх;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг яаралтай батлуулж, мөрдөх;
- Орхон гол, Туул гол болон бусад голуудын бохирдлыг бууруулах;
- Цэвэрлэх байгууламжуудын үйл ажиллагааны доголдолыг багасгах, шинээр цэвэрлэх байгууламж байгуулах;
- Хөрс, усны бохирдол;
- Төсвийн зарлагын зарцуулалт буюу Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хэрэгжилтийг орон нутагт хангаж ажиллах;
- Хөрөнгө санхүүгийн дутагдалыг шийдвэрлэх;


## Цаашид хэрэгжүүлэх ажлуудаас:

- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг УИХ-аар батлуулж, хэрэгжүүлэх /2018.02.09-нд өргөн барьсан/;
- АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн 2 дахь компакт гэрээний хүрээнд Улаанбаатар хотын ус хангамж, нөөцийг нэмэгдүүлэх, хаягдал усыг дахин ашиглах чиглэлээр хамтран ажиллах;
- Аймгийн төвүүд, нийслэлд усны хяналт-шинжилгээний тоног төхөөрөмжийг суурилуулах, хяналт-шинжилгээний сүлжээнд холбох ажлыг зохион байгуулах /500-д хүргэх/;
- Хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох гидрогеологийн хайгуул, судалгааны ажлыг улсын хэмжээнд үе шаттай зохион байгуулнах;
- Ганга нуур орчмын гидрогеологийн болон усны балансын 2017 онд хийсэн судалгааны үр дүнд үндэслэн нуурын экосистемийг тэтгэх, байнгын хяналт-шинжилгээ хийх боломжийг бүрдүүлнэ...



## Амьтны нөөц

■ Сүүлийн 20 гаруй жилийн судалгааны дүнгээр мазаалай 28, хүрэн баавгай 500, баданга хүдэр 6500, Төв Азийн минж 300, голын халиу 100, суусар булга 3500, цоохор ирвэс 900-1200, тахь 538, халиун буга 10000 орчим, хулан 10000, янгир 11000, аргаль 13000, молцог хандгай 16400, хавтгай 800-1200, цаа буга 140-200, хар сүүлтий 12000, зэрлэг гахай 35000 бөхөн, 10000 орчим тоо толгой тус тус бүртгэгдсэн байна. Мөн цагаан зээр 3 сая орчим байна.



- Агнуурын амьтны агнуурын бүс нутагт агнах,
- Үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих
- Амьтны гаралтай эд эрхтнийг ашиглах
- Гадаад улсад гаргахад шинжлэх ухааны үндэслэлтэй

2012-2017 онд нийт 15 аймаг ан агнуурын менежментийн төлөвлөгөөг шинээр боловсруулж, 15 аймгийн 56 сумын 76 агнуурын бүс нутгийн хилийн заагийг тогтоож, аймаг, сумын ИТХурлаар баталгаажуулсан байна.



## ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол орны ургамлын аймагт одоогоор 39 баг, 112 овог, 683 төрөлд хөмрөх 3127 дээд ургамал, 1574 замаг, 1030 зүйл хаг, 500 зүйл хөвд, 470 зүйлийн мөөг, 113 овог 3035 зүйлийн доод ургамал бүртгэгдсэн байна.

### Хэрэгжүүлж буй арга хэмжээ

1. Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах;
2. Устах аюулд орсон болон ашигт ургамлыг сэргээн нутагшуулах, тарьж ургуулах ажлыг бодлогоор дэмжин ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд дэрэвгэр жиргэрүү ургамлыг байгалиас түүж бэлтгэхийг 5 жилийн хугацаагаар хориглож, тарималжуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, бодлого эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
3. Нэн ховор, ховор ургамлын жагсаалтыг шинэчлэх зэрэг ажлууд хийгдэж байна.

## Хэрэгжүүлж буй бодлого



- Байгалийн ургамлын тухай хуулиар 133 зүйл “Нэн ховор”,
- Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор 355 зүйл ургамыг “Ховор” ургамлын жагсаалтад бүртгэсэн.
- Устах аюулд орсон болон устаж болзошгүй ховор ургамлыг судалгаагаар тогтоож 195 зүйл ургамлыг” Монгол улаан ном” -д
- Монголын ургамлын улаан дансны бүртгэлд нэн ховор 133 зүйл, ховор 15 зүйл ургамлыг олон улсын жишгийн дагуу үнэлгээ хийж хамгаалалтад аваад байна.

## Амьтан, ургамал

### Хэрэгжүүлж буй арга хэмжээ

- ❑ Ашиглах нөөцгүй болох өндөр эрсдэлтэй байгалийн **барагшуныг** экспортлохыг түр хугацаагаар хориглон хамгаалсан.
- ❑ Түймрийн аюултай үед ой, ойт хээрийн бүсэд **бугын эвэр түүх** үйл ажиллагааг түр хугацаагаар хориглосон.
- ❑ Тоо толгой сүүлийн жилүүдэд эрс цөөрч буй **монгол тарваганы нөөцийн судалгаа** хийж нөөц хомс тул ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барихыг хориглов.
- ❑ Тусгай зориулалтаар агнах агнуурын амьтын төлбөр, хураамжийн хэмжээг хуульд нийцүүлж батлав.

## Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

- ❑ Биологийн олон янз байдлын **үндэсний хөтөлбөрийг** хэрэгжүүлэх үйл ажиллагааны **төлөвлөгөө** боловсруулж хэрэгжүүлэх;
- ❑ **Генетик нөөцийг** ашиглах, түүний үр өгөөжийг шударгаар хүртээх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;
- ❑ Биологийн олон янз байдлын **дүйцүүлэн хамгааллын жишиг** төсөл хэрэгжүүлэх.
- ❑ **Ашигт ургамлын плантаци** байгуулах, нэн ховор, ховор, ашиглалтад нэн өртөмтгий зүйлүүдийг тарималжуулах
- ❑ Устах аюулд орсон болон аж ахуйн гоц ашигт амьтан, ургамлын зүйлийг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах ажлын **хөрөнгө, санхүүгийн механизм** байгуулах.

# Газрын хэвлийн нөөцийн бодлого ашиглалт

УИХ-ын 2014 оны 43  
дугаар тогтоолоор  
Ногоон Хөгжлийн  
бодлого батлагдсан

**Эрдэс баялгийн салбарт нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологи бүхий үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд:**

- ▶ Үүсмэл ордыг ашиглах, хаягдлыг дахин боловсруулах, тэргүүний технологи бүхий үйлдвэрийг дэмжих;
- ▶ Уул уурхайн томоохон төслүүдийг түшиглэн газрын доорх усны ордыг нөхөн сэргээх загвар төслүүдийг хэрэгжүүлэх


**Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлэх, уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:**

- ▶ Уурхайн хаалт болон нөхөн сэргээлт
- ▶ Байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээ
- ▶ Уламжлалт болон уламжлалт бус газрын тос
- ▶ Уул уурхайн салбарын орлогоос баялгийн сангийн хуримтлал
- ▶ Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон, бохирдолд өртсөн, атаршсан газрыг нөхөн сэргээх, ашиглах



## УУЛ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

- Байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаарх хууль тогтоомж, бодлого, урт болон дунд хугацааны стратеги, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангах.
- Уул уурхайн улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зардал, байгаль орчны хохирлыг тогтоох, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулах.



### Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлт



## ЭРХЗҮЙН ОРЧИН, ШИНЭЧЛЭЛ



Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д заасан эрхийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 30 орчим дүрэм, журам уул уурхайн ашиглалт, нөхөн сэргээлтийн үед мөрдөгдөж байна.

2015-2017 онд Байгаль орчны асуудал хариуцсан сайд болон холбогдох салбарын сайд нар хамтран “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”, “Нөхөн сэргээсэн газрыг хүлээн авах актын загвар”, “Байгаль орчны хохирол тооцох аргачлал”, “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал”, “Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний загвар, мэдээний маягт”-ыг баталсан.

2017 оны байдлаар уул уурхайн ашиглалтын 385 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө бүртгэгдсэнээс 318 төлөвлөгөө батлагдсан.



## Цаашид авч хэрэгжүүлэх арга ХЭМЖЭЭ

- Ашигт малтмал ашиглах үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх баталгааны хөрөнгө тооцох хувь хэмжээг нэмэгдүүлэх, барьцаа хөрөнгийг 3-5 жил дараалан буцааж аваагүй бол нөхөн сэргээлтэд татан ашиглах нөхцөлийг бий болгох,
- Ашигт малтмалын нөөц болон байгалийн нөөцөд учирсан хохирлын нөхөн төлбөрийн орлогоос эзэнгүй орхигдсон, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг санхүүжүүлэх эрхзүйн зохицуулалтыг бий болгох,
- Уурхай бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргийн төлөвлөлт, хэрэгжилтийн талаар мэдээллийн санг 2018 оны эхний улиралд багтаан байгуулах зорилго тавин ажиллаж байна.




# БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГО, ЗАРЦУУЛАЛТ /тэрбум төг/

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГООС ЗАРЦУУЛАХ ХУВЬ  
ХЭМЖЭЭ

Орлогын төрөл	Зарцуулах хувь хэмжээ
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	15 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн	50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн	15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн	85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн	35 хувь

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш /2013-2017/ нийт **333,7 тэрбум** төгрөгийн **орлого** орон нутгийн төсөвт төвлөрснөөс **52.1 тэрбум** төгрөгийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээхэд зарцуулжээ. Энэ нь нийт орлогын дөнгөж **15.6%** юм.



— Нийт орлого    — Орон нутаг зарцуулсан



## Байгалийн нөөцийн ашиглалтын орлого, эргэн зарцуулалт

**Тухайлбал:** 2016 онд нийт **90.0 тэрбум** төгрөгийн орлого орсноос **11.8 тэрбум** төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан.

**2017 онд** нийт **86.5 тэрбум** төгрөгийн орлого төвлөрүүлж **20.9 тэрбум** төгрөгийг байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулахаар төлөвлөн 87,4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 32,6 тэрбум төгрөгийг байгаль орчныг хамгаалахад зарцуулав.

**1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн** 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу 5 төрлийн нөөц ашигласны төлбөрөөс **2016 онд 70.3 тэрбум** төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу төвлөрсөн орлогоос **2016 онд 7.6 тэрбум** төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан.

**2017 онд** хуулийн дагуу **87.4 тэрбум** төгрөгийг орлого төвлөрүүлж, **13.9 тэрбум** төгрөгийг зарцуулсан.

**2. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн** 7 дугаар зүйлд заасны дагуу 4 төрлийн агаар бохирдуулагчийн төлбөрөөс **2016 онд 19.3 тэрбум** төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Агаарын бохирдлыг бууруулахад **2016 онд 4.3 тэрбум** төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан.


**2017 онд** хуулийн дагуу **36.6 тэрбум** төгрөгийг орлого төвлөрүүлж **4.95 тэрбум** төгрөгийг зарцуулсан.

**3. Харьяа төсвийн** байгууллагуудын үйл ажиллагааны орлогоос **2016 онд нийт 450.8 сая** төгрөг төвлөрүүлсэн.

**2017 онд** харьяа төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанаас нийт **280.5 сая** төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ОРЛОГО, ЗАРЦУУЛАЛТ тэрбум төгрөгөөр/

Агаарын бохирдлын төлбөрийн орлогоос 2011-2017 онд **нийт 170 тэрбум төгрөг улсын төсөвт орсноос 102.7 сая төгрөгийг зарцуулжээ.**




Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан орлогууд.

- Олборлосон түүхий нүүрсний төлбөр /нүүрсний килограмм тутамд 1 төгрөг/,
- Үйлдвэрлэсэн болон импортлосон органик уусгагчийн төлбөр /килограмм тутамд 10 төгрөг/,
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн төлбөр /тээврийн хэрэгслийн багтаамжаас хамаарч 6 ангилалаар 1800-9600 төгрөг/,
- Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодисын төлбөр /килограмм тутамд 1 төгрөг/

## БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН 2018 ОНЫ ТӨСӨВ

Сайдын багц дах зээл тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх хэлбэрээр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг санхүүжүүлж буй нь түр зуурын арга хэмжээ юм.

/тэрбум төгрөг/



# Анхаарал хандуулсанд баярлалаа

